



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

“Багануурын дулааны станц” ТӨХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн нийт гаргасан 45 377 115 /дөчин таван сая гурван зуун далан долоон мянга нэг зуун арван тав/ ширхэг энгийн хувьцааг 17 538 063 /арван долоон сая таван зуун гучин найман мянга жаран гурав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 62 915 178 /жаран хоёр сая есөн зуун арван таван мянга нэг зуун далан найм/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д зааснаар гаргасан хувьцааны тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 6 291 517 800 /зургаан тэрбум хоёр зуун ерөн нэгэн сая таван зуун арван долоон мянга найман зуу/ төгрөг байхаар тогтоож, үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол ирүүлж, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Багануурын дулааны станц” ТӨХК /Б.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ
ТОГТООЛ
2014.01.29